

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БНА-2024/04/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2024.02.05	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Ахлах аудитор М.Алтантуяа Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Нэг.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	11
3.1 Албан шаардлага.....	11
Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	12
Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Нэг.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101

Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2024.02.03 № 2/56

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, журам зөрчиж цалингийн зардлаас шагнал урамшуулал олгосон, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй, өмч

D- alban bichig 2024 A4 TOOT

5020216

Хөрөнгийн өөрчлөлттэй холбоотой өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гаргаагүй зэрэг зөрчил илэрсэн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түшингээс хэтрээгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 111 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ

D- alban bichig 2024 A4 TOOT

Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	715,231,536.25	427,142,437.51
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,035,000.00	22,090,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	9,035,000.00	22,090,000.00
3121	Төгрөг	9,035,000.00	22,090,000.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	9,035,000.00	22,090,000.00
33	АВЛАГА	27,746,341.20	26,882,650.54
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	265,713.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	18,977,844.20	7,773,077.64
335	Бусад авлага	8,768,497.00	18,843,859.90
3351	Байгууллагаас авах авлага	8,768,497.00	18,843,859.90
34	УРЬДЧИЛГАА	00.00	3,327,457.18
34600	Урьдчилж гарсан зардал	00.00	3,327,457.18
35	БАРАА МАТЕРИАЛ	678,450,195.05	374,842,329.79
351	Түүхий эд материал	509,274,970.94	287,473,013.10
35110	Тусгай зориулалттай материал	20,518,116.10	14,588,812.75
35130	Эм боох материал	488,756,854.84	272,884,200.35
354	Хангамжийн материал	169,175,224.11	87,369,316.69
35410	Бичиг хэргийн материал	3,832,000.00	3,320,800.00
35420	Аж ахуйн материал	13,466,461.00	13,255,744.00
35430	Сэлбэг хэрэгсэл	635,000.00	30,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,664,462.18	1,039,195.00
35450	Барилгын засварын материал	10,227,880.00	10,227,880.00
35460	Хүнсний материал	129,670,373.34	48,742,143.05
35470	Бусад хангамжийн материал	9,679,047.59	10,753,554.64
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,022,903,791.97	986,590,121.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,022,903,791.97	986,590,121.04
392	Биет хөрөнгө	858,202,750.55	821,528,142.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	817,245,798.51	817,117,098.51
39202	Хуримтлагдсан элэгдэл	-115,933,084.96	-144,682,181.26
39203	Авто-тээврийн хэрэгсэл	222,521,297.08	113,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-182,097,963.82	-95,716,666.86
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	261,022,793.51	307,770,721.51
39206	Хуримтлагдсан элэгдэл	-172,153,540.12	-197,050,326.65
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	115,165,375.24	103,414,580.34
39208	Хуримтлагдсан элэгдэл	-88,238,924.89	-83,385,083.58
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,042,350.00	420,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-371,350.00	-60,000.00
393	Биет бус хөрөнгө	164,701,041.42	165,061,979.03
39301	Програм хангамж	2,150,000.00	1,760,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,023,958.58	-1,273,020.97
39303	Бусад биет бус хөрөнгө	164,575,000.00	164,575,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,738,135,328.22	1,413,732,558.55
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	9,444,441.00	13,523,720.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,444,441.00	13,523,720.00
413	Өглөг	9,444,441.00	13,523,720.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	9,164,441.00	13,523,720.00
4136	Бусад өглөг	280,000.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	280,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,728,690,887.22	1,400,208,838.55
51	Засгийн газрын хувь оролцоо	1,728,690,887.22	1,400,208,838.55
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	755,146,079.04	755,146,079.04
51101	Өмч: - төрийн	755,146,079.04	755,146,079.04
512	Хуримтлагдсан үр дүн	217,355,999.23	-111,126,049.44
51210	Өмнөх үеийн үр дүн	301,106,154.13	301,106,154.13
51220	Тайлант үеийн үр дүн	-83,750,154.90	-412,232,203.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	756,188,808.95	756,188,808.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,738,135,328.22	1,413,732,558.55

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,053,931,620.20	3,995,095,782.48
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,172,861,167.90	1,036,487,818.48
120	Нийтлэг татварын бус орлого	2,172,861,167.90	1,036,487,818.48
120009	Бусад орлого	1,400,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,881,070,452.30	2,958,607,964.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,461,307,900.00	2,643,279,036.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,461,307,900.00	2,643,279,036.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	419,762,552.30	315,328,928.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	231,746,783.00	57,912,678.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	54,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	92,780,920.00	222,813,680.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,234,849.30	34,602,570.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,086,114,437.90	3,209,886,238.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,086,114,437.90	3,061,886,238.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,458,165,123.96	1,577,664,698.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	551,583,221.00	870,020,202.55
210101	Үндсэн цалин	351,085,341.00	493,312,315.55
210102	Нэмэгдэл	97,530,784.00	186,558,163.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,230,000.00	79,525,000.00
210104	Урамшуулал	64,737,096.00	110,624,724.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,694,313.62	107,829,852.03
210201	Тэтгэврийн даатгал	47,453,972.64	74,015,810.38
210202	Тэтгэмжийн даатгал	5,556,146.67	8,686,060.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,327,317.25	6,790,448.07
210204	Ажилгүйдлийн даатгал	1,032,443.10	1,667,046.90
210205	Эрүүл мэндийн даатгал	10,324,433.96	16,670,486.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,047,237.55	85,806,741.11
210301	Гэрэл, цахилгаан	7,717,493.55	8,687,961.11
210302	Түлш, халаалт	59,980,800.00	59,980,800.00
210303	Цэвэр, бохир ус	19,348,944.00	17,137,980.00
2104	Хангамж, бараа материалын зардал	86,966,626.34	169,684,900.59
210401	Бичиг хэрэг	22,536,145.00	15,008,680.00
210402	Тээвэр, шатахуун	34,683,420.00	46,972,643.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,919,691.59	2,873,465.24
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	770,000.00	665,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,964,031.00	21,423,441.00
210408	Бараа материал акталсны зардал	15,093,338.75	82,741,671.35
2105	Нормативт зардал	1,176,867,356.13	143,647,065.26
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,176,867,356.13	143,647,065.26
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,166,970.00	11,280,140.00
210604	Урсгал засвар	31,166,970.00	11,280,140.00
2107	Томилолт, зочны зардал	15,382,000.00	12,328,000.00
210702	Дотоод албан томилолт	15,382,000.00	12,328,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	341,574,036.00	55,752,267.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	331,064,368.00	46,660,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	995,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	844,748.00	235,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	227,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,530,800.00	8,159,067.60
210807	Газрын төлбөр	912,120.00	643,000.00

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	98,883,363.32	121,315,529.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,429,550.00	30,141,463.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,209,100.00	865,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	81,244,713.32	90,309,066.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,627,949,313.94	1,484,221,539.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,566,840,487.00	1,395,217,224.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	566,364,895.00	785,159,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төлөөс үзүүлэх дэмжлэг	936,868,052.00	599,238,724.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	63,607,540.00	10,818,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	59,654,551.24	88,684,315.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	59,654,551.24	88,684,315.47
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,454,275.70	320,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,454,275.70	320,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	148,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	148,000,000.00
225101	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) /ТӨҮГ/	00.00	148,000,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	967,817,182.30	785,209,544.09
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,051,567,337.20	1,113,691,592.76
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	321,642.44
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,051,567,337.20	1,113,369,950.32
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,051,567,337.20	-1,113,691,592.76
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-83,750,154.90	-328,482,048.67

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,159,793,607.90	3,133,740,378.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,400,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,400,000.00	00.00
120009	Бусад орлого	1,400,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,158,393,607.90	3,133,740,378.64
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,461,307,900.00	2,643,279,036.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,461,307,900.00	2,643,279,036.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	697,085,707.90	490,461,342.64
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	231,746,783.00	57,912,678.00
131103	ЗГНХ ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	54,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	92,780,920.00	222,813,680.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	283,177,421.20	192,157,140.44
131107	Урд оны үлдэгдлээс санхүүжих-Нэмэлт	35,380,583.70	17,577,844.20
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,147,790,557.90	3,118,815,378.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,147,790,557.90	3,118,815,378.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,499,213,399.76	1,626,820,761.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	551,583,221.00	870,285,915.55
210101	Үндсэн цалин	353,276,088.00	493,933,012.05
210102	Нэмэгдэл	96,714,078.00	186,464,718.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,172,655.00	79,326,807.41
210104	Урамшуулал	63,420,400.00	110,561,377.49

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,694,313.62	107,829,852.03
210201	Тэтгэврийн даатгал	47,453,972.64	74,015,810.38
210202	Тэтгэмжийн даатгал	5,556,146.67	8,686,060.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,327,317.25	6,790,448.07
210204	Ажилгүйдлийн даатгал	1,032,443.10	1,667,046.90
210205	Эрүүл мэндийн даатгал	10,324,433.96	16,670,486.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,047,237.55	85,806,741.11
210301	Гэрэл, цахилгаан	7,717,493.55	8,687,961.11
210302	Түлш, халаалт	59,980,800.00	59,980,800.00
210303	Цэвэр, бохир ус	19,348,944.00	17,137,980.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,823,941.59	26,873,195.24
210401	Бичиг хэрэг	6,790,700.00	5,804,330.00
210402	Тээвэр, шатахуун	17,971,500.00	10,768,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,919,691.59	2,930,203.24
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	770,000.00	665,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,372,050.00	6,704,812.00
2105	Нормативт зардал	273,934,729.00	176,623,577.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	273,934,729.00	163,623,577.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	13,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,081,280.00	12,745,640.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,094,500.00	2,008,000.00
210604	Урсгал засвар	29,986,780.00	10,737,640.00
2107	Томиллот, зочны зардал	15,382,000.00	12,328,000.00
210702	Дотоод албан томиллот	15,382,000.00	12,328,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	411,990,527.00	98,227,587.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	399,775,859.00	89,218,788.00
210803	Даатгалын үйлчилгээ	995,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	844,748.00	235,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,330,800.00	8,075,599.60
210807	Газрын төлбөр	912,120.00	643,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,676,150.00	236,100,253.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,867,050.00	235,445,253.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,809,100.00	655,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,648,577,158.14	1,491,994,617.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,568,490,487.00	1,395,217,224.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	566,364,895.00	785,159,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	936,868,052.00	599,238,724.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	65,257,540.00	10,818,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	61,054,551.24	88,684,315.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	61,054,551.24	88,684,315.47
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,032,119.90	8,093,077.64
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,032,119.90	8,093,077.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	12,003,050.00	14,925,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,248,050.00	1,870,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,248,050.00	1,870,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,248,050.00	1,870,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,248,050.00	1,870,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-7,248,050.00	-1,870,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	4,755,000.00	13,055,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,280,000.00	9,035,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,035,000.00	22,090,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	-246,864,986.42	1,264,469,901.57
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	-246,864,986.42	1,264,469,901.57
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	34,459,361.64	34,459,361.64
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	217,355,999.23	1,728,690,887.22
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	217,355,999.23	1,728,690,887.22
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	217,355,999.23	1,728,690,887.22
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-328,482,048.67	-328,482,048.67
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	-111,126,049.44	1,400,208,838.55

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,656,235,100.00	2,554,594,720.53	101,640,379.47	96.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,656,235,100.00	2,554,594,720.53	101,640,379.47	96.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,247,340,800.00	1,159,377,496.53	87,963,303.47	92.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	942,299,100.00	870,285,915.55	72,013,184.45	92.4
210101	Үндсэн цалин	536,649,500.00	493,933,012.05	42,716,487.95	92.0
210102	Нэмэгдэл	255,608,400.00	186,464,718.60	69,143,681.40	72.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	84,879,000.00	79,326,807.41	5,552,192.59	93.5
210104	Урамшуулал	65,162,200.00	110,561,377.49	-45,399,177.49	169.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	117,787,300.00	107,829,852.03	9,957,447.97	91.5
210201	Тэтгэврийн даатгал	80,095,300.00	74,015,810.38	6,079,489.62	92.4
210202	Тэтгэмжийн даатгал	9,423,000.00	8,686,060.11	736,939.89	92.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,538,400.00	6,790,448.07	747,951.93	90.1
210204	Ажилгүйдлийн даатгал	1,884,600.00	1,667,046.90	217,553.10	88.5
210205	Эрүүл мэндийн даатгал	18,846,000.00	16,670,486.57	2,175,513.43	88.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,111,400.00	85,806,741.11	4,304,658.89	95.2
210301	Гэрэл, цахилгаан	10,134,600.00	8,687,961.11	1,446,638.89	85.7
210302	Түлш, халаалт	62,757,900.00	59,980,800.00	2,777,100.00	95.6
210303	Цэвэр, бохир ус	17,218,900.00	17,137,980.00	80,920.00	99.5
2104	Хангамж, бараа материалын зардал	26,874,700.00	26,873,195.24	1,504.76	100.0
210401	Бичиг хэрэг	6,003,600.00	5,804,330.00	199,270.00	96.7
210402	Тээвэр, шатахуун	13,808,000.00	10,768,850.00	3,039,150.00	78.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,385,400.00	2,930,203.24	455,196.76	86.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	614,900.00	665,000.00	-50,100.00	108.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,062,800.00	6,704,812.00	-3,642,012.00	218.9
2105	Нормативт зардал	14,734,500.00	14,529,100.00	205,400.00	98.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,726,100.00	1,529,100.00	197,000.00	88.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,008,400.00	13,000,000.00	8,400.00	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,163,800.00	14,065,640.00	98,160.00	99.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,385,300.00	3,328,000.00	57,300.00	98.3
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	600	0	600.00	0.0
210604	Урсгал засвар	10,777,900.00	10,737,640.00	40,260.00	99.6

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
2107	Томилолт, зочны зардал	13,578,000.00	12,328,000.00	1,250,000.00	90.8
210702	Дотоод албан томилолт	13,578,000.00	12,328,000.00	1,250,000.00	90.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,621,800.00	9,558,799.60	63,000.40	99.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	29,600.00	0	29,600.00	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	16,400.00	0	16,400.00	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	235,200.00	235,200.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	64,700.00	55,000.00	9,700.00	85.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,625,600.00	8,625,599.60	0.40	100.0
210807	Газрын төлбөр	650,300.00	643,000.00	7,300.00	98.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,170,200.00	18,100,253.00	69,947.00	99.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,513,100.00	17,445,253.00	67,847.00	99.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	657,100.00	655,000.00	2,100.00	99.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,408,894,300.00	1,395,217,224.00	13,677,076.00	99.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,408,894,300.00	1,395,217,224.00	13,677,076.00	99.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	785,159,700.00	785,159,700.00	0.00	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	612,886,500.00	599,238,724.00	13,647,776.00	97.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,848,100.00	10,818,800.00	29,300.00	99.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,656,235,100.00	2,643,279,036.00	12,956,064.00	99.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,656,235,100.00	2,643,279,036.00	12,956,064.00	99.5
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,656,235,100.00	2,643,279,036.00	12,956,064.00	99.5

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	687,085,707.00	454,368,265.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	685,335,707.90	454,368,265.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	666,303,588.00	454,368,265.00
2105	Нормативт зардал	271,772,729.00	162,094,477.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	271,772,729.00	162,094,477.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	394,530,859.00	74,273,788.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	394,530,859.00	74,273,788.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	218,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		218,000,000.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	19,032,119.90	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,750,000.00	00.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,750,000.00	00.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	687,085,707.90	462,461,342.64
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	687,085,707.90	462,461,342.64
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	231,746,783.00	57,912,678.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	54,000,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	92,780,920.00	226,102,680.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	273,177,421.00	178,445,984.64
131106	Төсвийн урамшуулал	35,380,583.70	00.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 183,192.4 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Санхүүгийн тайланд Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс олгож буй вакцины 4-р улирлын зарлага болох 183,192.4 мянган төгрөгийг нягтлан бодогч санхүүгийн тайланд бүртгээгүй байгаа нь УСНББОУС-12 бараа материал, мөн үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 243,578.3 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс 243,578.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 10,477.5 мянган төгрөгийн материаллагаар тооцсон залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 18,123.5 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1 Байгууллагын даргын 2023.04.17-ны өдрийн Б/21 дүгээр тушаалаар байгууллагын хамтын гэрээний 5.1 дэх заалт болох “Улсын чанартай спортын тэмцээн уралдаанд амжилттай оролцсон бол...” гэсэн заалтыг үндэслэн салбарын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон нэр бүхий 3 ажилтанд 1 сарын үндсэн цалинтай тэмцэх хэмжээний урамшууллыг цалингийн зардлаас олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1³, 16 дугаар зүйлийн 16.5.5⁴ дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийг хэмнэлттэй, ашигтай зарцуулж, цаашид алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

3.1.2 Тайлант хугацааны сэлбэг хэрэгсэл, урсгал засварын зардлаас зарцуулсан 10,592.6 мянган төгрөг мөн акталсан 20,661.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 82,741.7 мянган төгрөгийн бараа материал, бусад байгууллагад шилжүүлсэн 119,104.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3⁵ дахь заалт, Эрүүл мэндийн газрын даргын А/52 дугаар тушаалаар баталсан "Баянхонгор аймгийн эрүүл мэндийн газрын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журам" -ын 5.1⁶ дэх заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын тээврийн хэрэгслийн сэлбэг хэрэгсэл болон урсгал засвартай холбоотой тооцоолол, мөн акталсан болон шилжүүлж буй

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

³ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

⁴ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

⁵ Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгахад дараах журмыг баримтална

⁶ Зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу хуулийн этгээдийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах, данснаас хасах зэрэг эд хөрөнгийн зохицуулалт, төрийн өмчийн үр ашгийг дээшлүүлэх асуудлыг судалж, санал, зөвлөмж, дүгнэлт гаргана

хөрөнгийг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3.1.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны А/11 дүгээр тушаалаар 5,595.0 мянга, А39 дугаар тушаалаар 2,500.0 мянга, нийт 8,095 мянган төгрөгийг эрүүл мэндийн салбарын удирдах ажилтын зөвлөгөөнийг зохион байгуулан шагнал урамшуулал, хоол цайны зардалд зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3⁷ дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1.3⁸ дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр шагнал урамшуулал олгохгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
							Үүнээс		Залруулаг үй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд буруу бүртгэсэн	0	0			0	0	0	0		
Санхүүгийн тайланд бүртгээгүй	1	183,192.4	1	183,192.4			1	183,192.4		
Дүн	1	183,192.4	1	183,192.4			1	183,192.4		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацааны сэлбэг хэрэгсэл, урсгал засварын зардлаас зарцуулсан 10,592.6 мянган төгрөг мөн акталсан 20,661.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 82,741.7 мянган төгрөгийн бараа материал, бусад байгууллагад шилжүүлсэн 119,104.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргаагүй байна.	1	233,100.8			1	233,100.8		
Байгууллагын даргын 2023.04.17-ны өдрийн Б/21 дүгээр тушаалаар байгууллагын хамтын гэрээний 5.1 дэх заалтыг үндэслэн салбарын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон нэр бүхий 3 ажилтанд 1 сарын үндсэн цалинтай тэмцэх хэмжээний урамшууллыг цалингийн зардлаас олгосон байна.	1	2,382.5			1	2,382.5		
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, 15 дугаар зүйлийн 15.1.3 дэх заалтыг зөрчиж Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны А/11 дүгээр тушаалаар 5595.0 мянга, А39 дугаар тушаалаар 2500.0 мянга, нийт 8095 мянган төгрөгийг эрүүл мэндийн салбарын удирдах ажилтын зөвлөгөөнийг зохион	1	8,095.0			1	8,095.0		

⁷ Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно.

⁸ хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

байгуулан шагнал урамшуулал, хоол цайны зардалд зарцуулсан байна.								
Нийт дүн	3	243,578.3				3	243,578.3	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ		1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ		1			1			

-----oO-----